



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 546

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас
балансад шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Архивын ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 414,320,342.00 (дөрвөн зуун арван дөрвөн сая гурван зуун хорин мянга гурван зуун дөчин хоёр) төгрөгийн балансын үнэ, 32,800,360.44 (гучин хоёр сая найман зуун мянга гурван зуун жаран төгрөг дөчин дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Дагдан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 11 дүгээр сарын 23 ны өдрийн
576 дугаар тогтоолын хавсралт

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, "УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ"
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэмжээ	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Дэд өртөөний барилга, 10 кв-ын 800 квагийн 2 ш трансформатор, ХТП-4756	2016	127,629,384.00	1	127,629,384.00	10,103,992.71	117,525,391.29
2	Гадна кабель шугам	2016	286,690,958.00	1	286,690,958.00	22,696,367.73	263,994,590.27
	Нийт дүн				414,320,342.00 (дөрвөн зуун арван дөрвөн сая гурван зуун хорин мянга гурван зуун дөчин хоёр)	32,800,360.44 (гучин хоёр сая найман зуун мянган гурван зуун жаран төгрөг дөчин дөрвөн мөнгө)	381,519,981.56 (гурван зуун наян нэгэн сая таван зуун арван есөн мянга есөн зуун наян нэгэн төгрөг тавин зургаан мөнгө)